

ЛИЛАГИЙН СОНГОЛТ

Ли́ла зөвийг сонгохыг хүсэж байлаа.



Каролина Марин
(Бодит түүхээс сэдэвлэв)

“Их Эзэн надад ариун сүм өгсөн” (Хүүхдийн дууны ном, 73).

“Судрын цаг боллоо!” гэж Ли́ла хэлэв. Ли́ла өөрийн эмэгтэй дүү Аника, эрэгтэй дүү Свэтан хоёрт ном уншиж өгөх дуртай байв. Удахгүй Ли́ла баптисм хүртэнэ! Үүнд бэлтгэж, тэр өдөр бүр судраа уншихыг хүсдэг байв.

Ли́ла судрын түүхийн номынхоо эхний хуудсыг гарган, Аника, Свэтан хоёрыг хажуудаа суулган, зураг үзэхэд нь туслав.

“Анхааралтай сонсоорой. Би дараа нь асууна шүү” гэж Ли́ла хэлээд, эхний бүлгийг уншиж эхэллээ.

“Бид төрөхөөсөө өмнө тэнгэрт амьдарч байсан. Бидэнд бие махбод байгаагүй. Бид сүнснүүд байсан” гэж Ли́ла уншив.

Ли́ла, Аника, Свэтан гурав цагаан хувцастай хүмүүсийн зургийг харав.

“Эхний асуултаа бэлэн үү?” гээд, Ли́ла Аникагаас “Чи төрөхөөсөө өмнө хаана байсан бэ?” гэхэд Аника алгаа ташин, “Тэнгэрт!” гэж хариулав.

“Тийм ээ” гэж Ли́ла хэлээд, “Тэгвэл Свэтан хаанаас ирсэн бэ?” гэхэд

“Тэр ч бас тэнгэрээс ирсэн” гэж Аника хэллээ. Свэтаных хөхрөөд, гараа ам руугаа хийхэд Ли́ла, Аника хоёр инээлдэв. Свэтан бол Аргентины хамгийн хөөрхөн нэг настай хүүхэд!

“Манай гэрийнхэн бүгдээрээ тэнгэрээс ирсэн. Есүс ч бас. Бидэнд Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрахад туслахаар Тэр ирсэн” гээд, Ли́ла тэр хуудсанд байгаа Есүсийн зураг руу заав.

Уншиж дууссаныхаа дараа, Ли́ла тэнгэрт Есүстэй хамт амьдрах ямар байдаг тухай бодсоор байлаа. Тэр Түүнтэй адил болж, үргэлж зөвийг сонгохыг хүссэн.

Маргааш нь сургууль дээр өглөөний хоолоо идэхээр дугаарлан зогсоход Ли́лагийн гэдэс дуугарав. Сэньора Руиз импанадасыг тавган дээр нь тавихад түүнд бараг л амтагдаж байлаа. Ямар гоё үнэртэж байна аа!

Тэгээд Сэньора Руиз Ли́лад сүү аягалж өгөхөд Ли́ла яана аа гэж бодов. Сүү ердийнхөөсөө илүү бараан

харагдаж байв. Заримдаа сургууль уух юманд кофе эсвэл цай нэмчихдэг юм.

“Өнөөдрийн сүүнд кофе эсвэл цай хийсэн үү?” гэж Ли́ла асуув.

Сэньора Руиз гараараа дохин, “Жаахан кофе нэмсэн. Чамд бараг амтагдахгүй ээ” гэв.

Ли́ла тэр мөчид бодлоо. Тэр хэрхэн Есүстэй адил болж, зөвийг сонгохыг хүсдэг байснаа санав. Кофе ууж болохгүй гэж бошиглогчид хэлснийг тэр мэдэж байлаа.

“Үгүй ээ, баярлалаа. Би өнөөдөр сүү уухгүй” гэж Ли́ла хэлээд, Сэньора Руиз руу инээмсэглэв. Тэгээд хоолоо идэхээр суулаа.

Тэр үдэш Ли́ла гал тогооны өрөөнд аавдаа аяга таваг угаахад нь тусалж байв. Тэр судрын түүхийг, бас сүүний талаар бодож байв.

“Папи?”

“За?” гэж Папи хэллээ.

“Тэнгэрлэг Эцэг яагаад биднийг бие махбодтой байгаасай гэж хүссэн юм бол?”

Папи тавгийг усаар зайлангаа бодоод, “Бид Түүнтэй адил болохын тулд Тэр бидэнд бие махбод өгсөн.

Чиний бие махбод бол сүнсний чинь гэр орон юм. Бид бие махбодоо ариун сүм гээд байдгийн учир нь энэ” гэлээ.

Ли́ла толгой дохив. Тэр энэ талаарх нэгэн дуут Хүүхдийн хэсэгт заримдаа дуулдаг байв. “Тэгээд л Тэнгэрлэг Эцэг биднийг өөрсдийнхөө биед анхаарал тавьж байхыг хүсдэг юм уу?”

“Яг тийм” гэж Папи хэлэв.

“Өнөөдөр сургууль дээр сүүнд кофе хийсэн байсан. Би уугаагүй л дээ. Би өөрийнхөө ариун сүмд анхаарал тавихыг хичээж байгаа” гэж Ли́ла хэллээ.

“Би чамаар бахархдаг шүү” гэж Папи хэлээд, гараа арчаад, Ли́лаг тэвэрлээ.

Ли́ла Папиг чанга тэврэв. Тэр Тэнгэрлэг Эцэгийн түүнд өгсөн биед анхаарал тавихдаа баяртай байлаа. ● *Зохиогч нь Аргентины Корриентест амьдардаг.*

Энэ түүхэнд гарч буй гэр бүл Аргентинд амьдардаг. Тэдний улс орны тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл дараагийн өгүүллийг уншаарай.